



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

Үл хөдлөх хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1,3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.2, 6.2.3, 6.4.3, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Татварын ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 3 нэрийн, 9,122,810.00 (есөн сая нэг зуун хорин хоёр мянга найман зуун арван) төгрөгийн балансын үнэ, 1,269,953.00 (нэг сая хоёр зуун жаран есөн мянга есөн зуун тавин гурван) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Татварын ерөнхий газрын дарга, Б.Заяабал, Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Цэрэнболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан барилгыг акталж, данснаас хасах, хоёрдогч түүхий эд болгон ашиглах буюу худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Грашийн барилга, хашааг буулгаж, чөлөөлсөн газрыг байгууллагын албан конторын зориулалтаар нь ашиглах, газрыг нөхөн сэргээх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРАНГЭРЭЛ

0000170



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн ...
81 дугаар тогтоолын хавсралт

Сэлэнгэ аймгийн Татварын хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй акталж, данснаас хасах хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Балансын дүн (төгрөгөөр)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөгөөр)	Үлдэгдэл өртөг (төгрөгөөр)
1	3 машины граж	2000	ш	1	8,456,410.00	8,456,410.00	603,553.00	7,852,857.00
2	Хашаа /темер/	1995	ш	1	266,400.00	266,400.00	266,400.00	0.00
3	Хашаа /темер/	2000	ш	1	400,000.00	400,000.00	400,000.00	0.00
						9,122,810.00	1,269,953.00	7,852,857.00
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН					9,122,810.00 (есөн сая нэг зуун хорин хоёр мянга найман зуун арван)	1,269,953.00 (нэг сая хоёр зуун жаран есөн мянга есөн зуун тавин гурван)	7,852,857.31 (долоон сая найман зуун тавин хоёр мянга найман зуун тавин долоон)